ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир спортын үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийх аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2024/37/НА-СТА-ТЕЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Улаанбаатар хот<br><br>2023 он | Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Энхдалай<br>Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: А.Даваадорж<br>Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn<br><br>Аудитор: Я.Марал-Эрдэнэ<br>Утас: 261628 Цахим хаяг: maral-erdeneya@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1156

танай ____________-ны № ____________-т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ОЛИМП, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ДАРГА Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 42,861.29 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон 974.9 сая төгрөгийн ерөнхий тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.Тухайлбал:

- Тухайн жилийн төсвийн тухай хуулиар тус ерөнхийлөн захирагчийн багцад баталсан, аймгуудын Засаг даргын Тамгын газарт эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 12 барилгын 12,325.1 сая төгрөгийн төсвийн санхүүжилтийг Сангийн яамнаас шууд шилжүүлснээс Төсвийн ерөнхийлөн захирагч хуулиар хүлээсэн захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй;
- Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 он, 2023 онд санхүүжүүлэх батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч байгууллага нь цаашид хэрэгжүүлэх боломжгүй болж бүрэн зогссон зэрэг барьцаа хөрөнгийн дансанд байршиж байгаа нийт 1,172.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;

- Биеийн тамир, спортын улсын хороо нь "Олон улсын залуучуудын ногоон наадам"-ын бэлтгэл ажлын хүрээнд байгуулсан гэрээний дагуу олгосон нийт 2,620.8 сая төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хянаагүй, хугацаанд нь хүлээн аваагүй, баталгаажуулаагүй;
- Нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох өртгийн дээд хязгаараас хэтэрсэн, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаагүй нийт 1,005.2 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, ангилал буруу бүртгэсэн, эд хөрөнгийн тооллого хийгээгүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар шилжүүлэн төсөв хооронд гүйлгэн зарцуулсан зэрэг нийт 2,522.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.7, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.6, 40 дүгээр зүйлийн 40.1, 43 дугаар зүйлийн 43.5, 45 дугаар зүйлийн 45.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 46 дугаар зүйлийн 46.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль, Монгол Улсын засгийн газрын тухай хуульд 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хороог шинээр байгуулж, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир спортын үндэсний хорооны даргын эрхлэх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого, мэргэжлийн спортын хөгжлийн асуудал, үндэсний уламжлалт спортыг дэмжих, хөгжүүлэх бодлого, биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх асуудлын хүрээнд Биеийн тамир, спортын улсын хороо, 21 аймаг, 9 дүүргийн Биеийн тамир спортын хороо, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Спортын анагаах ухааны эрдэм шинжилгээний төв, “Буянт-Ухаа спортын ордон” ТӨААТҮГ, “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ бүтэцтэй үйл ажиллагаа явуулахаар зохион байгуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Цаг гаргая” биеийн тамирын арга хэмжээ, "Эрүүл Монгол хүн" үндэсний фестиваль, Монголын хүүхдийн спортын зуны VII их наадам, "Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль, "Улаанбаатар 2023" Зүүн Азийн залуучуудын наадам, “Улаанбаатар их дуулга 2023” жүдо бөхийн Олимпын эрх олгох дэлхийн зэрэглэлийн тэмцээн, Тусгай Олимпын дэлхийн зуны наадмыг амжилттай зохион байгуулж, төсвөөс нийт 19,200.0 сая төгрөг зарцуулсан байна.

Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хороо нь улсын хэмжээнд Нийтийн Биеийн тамир, спортын хөгжил хөтөлбөрийн хүрээнд биеийн тамир, спортын чиглэлийн төрийн бус байгууллага, холбоо, клубууд нийт 110 байгууллагатай хамтран ажиллаж, төрийн зарим чиг үүргийг гэрээний дагуу шилжүүлэн дэмжлэг үзүүлж, 330 түр ажлын байр бий болгон ажилласан байна.

Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 243 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 806 дугаар тогтоолоор "Буянт-Ухаа спортын ордон" ТӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй 249 нэрийн 51,888.7 сая төгрөгийн анхны өртөгтэй, 4,292.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгө, 55.1 сая төгрөгийн авлага, 44.7 сая төгрөгийн бараа материал, 154.4 сая төгрөгийн өр төлбөрийг "Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв" ТӨААТҮГ-ын балансад шилжүүлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichig\2024\0425 SNAG-25 Docx

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

*/мянган төгрөгөөр/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | - | **187,710,938.6** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | 5,184,177.8 |
| 33 | АВЛАГА | - | 2,094,400.4 |
| 34 | УРЬДЧИЛГАА | - | 4,097,030.5 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | - | 4,079,230.9 |
| **360** | **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | - | **172,256,098.9** |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | - | **193,217,060.1** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | - | **193,217,060.1** |
| 39200 | Биет хөрөнгө | - | 179,286,670.2 |
| 39300 | Биет бус хөрөнгө | - | 13,930,389.8 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | - | **380,927,998.6** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | **6,306,679.6** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 6,306,679.6 |
| 41200 | Богино хугацаат зээлийн өглөг | - | 97,713.3 |
| 41300 | Өглөг | - | 6,208,966.3 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | - | **374,621,319.0** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | - | 374,621,319.0 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | - | 53,863,018.9 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | - | 31,367,602.2 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | - | 985,082.6 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | - | 241,504,978.7 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | - | 46,900,636.6 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | - | **380,927,998.6** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

*/мянган төгрөгөөр/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **-** | **265,900,964.3** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 152,073,212.1 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 152,073,212.1 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | - | 113,827,752.1 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | - | 82,838,998.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 82,838,998.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 72,533,461.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | - | 15,031,957.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | - | 1,849,008.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | - | 8,445,971.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 929,262.9 |
| 2105 | Нормативт зардал | - | 250,932.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 1,155,245.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 129,715.1 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 18,496,707.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 26,244,661.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 10,305,536.9 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-** | **183,061,965.8** |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | - | 20.2 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 13,817,049.5 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-** | **169,244,936.5** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

*/мянган төгрөгөөр/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | | **126,755,575.5** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | **735,469.0** |
| 110 | Орлогын албан татвар | | 735,469.0 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 735,469.0 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **9,821,428.2** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 9,821,428.2 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **116,198,678.2** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **86,730,218.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **86,730,218.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **76,267,154.0** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 15,238,508.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 1,889,910.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 8,511,285.6 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 540,624.5 |
| 2105 | Нормативт зардал | | 144,764.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 2,101,611.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 131,434.8 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 20,127,411.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 27,581,604.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **10,463,064.5** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | | **40,025,356.9** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | | **34,624,698.8** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **34,624,698.8** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 34,624,698.8 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | | **(34,624,698.8)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | | **(216,480.3)** |
| 14 | Бусад эх үүсвэр | | 58,000.0 |
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | | **274,480.3** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | | **5,184,177.8** |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 5,184,177.8 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

*/мянган төгрөгөөр/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - |
| **10** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 204,150,034.1 | 204,150,034.1 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 204,150,034.1 | 204,150,034.1 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 241,265.80 | 241,265.80 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | 985,082.6 | 985,082.6 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 169,244,936.5 | 169,244,936.5 |
| **20** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **374,621,319.0** | **374,621,319.0** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 111,870,636,100.00 | 108,819,190,473.06 | 3,051,445,626.94 | 97.3 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 63,047,470,500.00 | 60,000,895,145.06 | 3,046,575,354.94 | 95.2 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 57,650,461,100.00 | 54,870,611,305.73 | 2,779,849,794.27 | 95.2 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 15,025,692,000.00 | 14,031,572,800.10 | 994,119,199.90 | 93.4 |
| 210101 | Үндсэн цалин | 8,982,252,600.00 | 8,503,146,365.21 | 479,106,234.79 | 94.7 |
| 210102 | Нэмэгдэл | 3,156,874,600.00 | 2,521,853,230.27 | 635,021,369.73 | 79.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,868,833,400.00 | 1,528,476,882.64 | 340,356,517.36 | 81.8 |
| 210104 | Урамшуулал | 1,017,731,400.00 | 1,393,781,996.83 | (376,050,596.83) | 136.9 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 84,314,325.15 | (84,314,325.15) | 0.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,938,342,500.00 | 1,745,185,167.60 | 193,157,332.40 | 90.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,301,553,100.00 | 1,199,618,623.22 | 101,934,476.78 | 92.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 155,167,200.00 | 141,315,866.15 | 13,851,333.85 | 91.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 136,323,900.00 | 111,640,537.41 | 24,683,362.59 | 81.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 35,163,400.00 | 26,955,495.52 | 8,207,904.48 | 76.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 310,134,900.00 | 265,654,645.30 | 44,480,254.70 | 85.7 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 230,531,400.00 | 219,042,137.58 | 11,489,262.42 | 95.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 106,230,800.00 | 96,419,014.47 | 9,811,785.53 | 90.8 |
| 210302 | Түлш, халаалт | 87,416,400.00 | 86,229,589.00 | 1,186,811.00 | 98.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 36,884,200.00 | 36,393,534.11 | 490,665.89 | 98.7 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 374,126,800.00 | 361,821,708.98 | 12,305,091.02 | 96.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 48,289,100.00 | 50,065,600.00 | (1,776,500.00) | 103.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 75,018,600.00 | 71,776,969.00 | 3,241,631.00 | 95.7 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 63,016,000.00 | 60,548,203.70 | 2,467,796.30 | 96.1 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 23,700,900.00 | 18,996,196.00 | 4,704,704.00 | 80.1 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 164,102,200.00 | 160,434,740.28 | 3,667,459.72 | 97.8 |
| **2105** | **Нормативт зардал** | 505,500,000.00 | 126,369,184.50 | 379,130,815.50 | 25.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 500,000,000.00 | 120,869,184.50 | 379,130,815.50 | 24.2 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,500,000.00 | 5,500,000.00 | - | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,180,476,200.00 | 2,879,672,844.28 | 300,803,355.72 | 90.5 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,559,169,200.00 | 1,541,803,962.00 | 17,365,238.00 | 98.9 |
| 210602 | Тавилга | 640,000,000.00 | 631,969,975.00 | 8,030,025.00 | 98.7 |
| 210604 | Урсгал засвар | 981,307,000.00 | 705,898,907.28 | 275,408,092.72 | 71.9 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 74,701,500.00 | 66,275,153.00 | 8,426,347.00 | 88.7 |
| 210702 | Дотоод албан томилолт | 74,701,500.00 | 66,275,153.00 | 8,426,347.00 | 88.7 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 20,494,567,700.00 | 19,713,148,643.94 | 781,419,056.06 | 96.2 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,383,672,700.00 | 19,625,848,270.94 | 757,824,429.06 | 96.3 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 16,196,000.00 | 9,186,000.00 | 7,010,000.00 | 56.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 10,147,500.00 | 8,499,770.00 | 1,647,730.00 | 83.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 5,046,100.00 | 2,597,751.00 | 2,448,349.00 | 51.5 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 1,909,200.00 | 984,800.00 | 924,400.00 | 51.6 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 25,401,000.00 | 23,149,230.00 | 2,251,770.00 | 91.1 |
| 210807 | Газрын төлбөр | 52,195,200.00 | 42,882,822.00 | 9,312,378.00 | 82.2 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,826,523,000.00 | 15,727,523,665.75 | 98,999,334.25 | 99.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,811,007,700.00 | 15,719,172,615.75 | 91,835,084.25 | 99.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,515,300.00 | 8,351,050.00 | 7,164,250.00 | 53.8 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,397,009,400.00 | 5,130,283,839.33 | 266,725,560.67 | 95.1 |
| **2131** | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 115,045,000.00 | 106,813,021.00 | 8,231,979.00 | 92.8 |
| **213102** | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 115,045,000.00 | 106,813,021.00 | 8,231,979.00 | 92.8 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,281,964,400.00 | 5,023,470,818.33 | 258,493,581.67 | 95.1 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 4,630,000,000.00 | 4,420,690,000.00 | 209,310,000.00 | 95.5 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 536,428,300.00 | 493,803,564.33 | 42,624,735.67 | 92.1 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 115,536,100.00 | 108,977,254.00 | 6,558,846.00 | 94.3 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 48,823,165,600.00 | 48,818,295,328.00 | 4,870,272.00 | 100.0 |
| 220001 | Барилга байгууламж | 48,823,165,600.00 | 48,818,295,328.00 | 4,870,272.00 | 100.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 111,870,636,100.00 | 108,820,540,172.47 | 3,050,095,927.53 | 97.3 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 111,870,636,100.00 | 108,749,810,273.67 | 3,120,825,826.33 | 97.2 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 111,870,636,100.00 | 108,749,810,273.67 | 3,120,825,826.33 | 97.2 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 0.00 | 70,729,898.80 | (70,729,898.80) | |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 70,729,898.80 | (70,729,898.80) | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 36 | 36 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 36 | 36 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 820 | 820 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **11,590,502,099.18** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **11,590,502,099.18** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **9,440,038,709.73** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **704,150,850.81** |
| 210101 | Үндсэн цалин | | 514,502,357.73 |
| **2102** | **Нэмэгдэл** | | **76,315,773.08** |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 1,862,500.00 |
| **210104** | **Урамшуулал** | | **15,300,720.00** |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 96,169,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **79,748,943.69** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 56,702,270.92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 6,039,503.34 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 4,926,908.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 1,047,058.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 11,033,202.28 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **91,757,669.95** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 14,759,953.95 |
| 210302 | Түлш, халаалт | | 76,774,966.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 222,750.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **162,290,331.00** |
| 210401 | Бичиг хэрэг | | 1,842,560.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 25,242,570.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 1,752,740.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 6,000,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 615,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 126,837,461.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | **18,395,000.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 900,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 17,495,000.00 |
| **2103** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **457,774,830.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 256,009,100.00 |
| 210602 | Тавилга | | 57,977,900.00 |
| 210604 | Урсгал засвар | | 143,787,830.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **65,159,600.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | | 2,608,400.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | 62,551,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **256,439,133.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 256,140,825.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 284,600.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 13,708.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **7,604,322,351.28** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 7,604,322,351.28 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **2,150,463,389.45** |

| | | | |
|---|---|---|---|
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 2,055,089,556.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | 15,526,153.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 1,449,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 590,063,403.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **95,373,833.45** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжилтээс төвлөрүүлэх шилжүүлэг | | 95,373,833.45 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **11,590,502,099.18** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **11,590,502,099.18** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 39,000,000.00 |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | 18,190,453.10 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 6,714,071,032.06 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 3,866,145,272.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 971,285,795.12 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 3.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 37 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 22 байгууллагад дүгнэлт гаргаж, 15 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “**Өөрчлөлтгүй**” 18 дүгнэлт, Өмнөговь аймгийн Биеийн тамир, спортын газар, Биеийн тамир, спортын улсын хороо, Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв ТӨААТҮГ, Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-т **“Хязгаарлалттай”** дүгнэлт өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 30,536.5 сая төгрөгийн 82 зөрчил илэрснээс 1,219.2 сая төгрөгийн 12 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13,435.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 29 албан шаардлага хүргүүлж, 15,882.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 41 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

### 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.2.1 Албан шаардлага

1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль болон гэрээний үүрэг зөрчигдөж 12,066.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 5 төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй байна. Үүнд:

- XIX.1.32 Спорт цогцолборын барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум/ 5,253.9 сая төгрөг,
- XIX.1.10 Спорт цогцолборын барилга, 105 суудал /Баян-Өлгий, Ногооннуур сум/ 1,799.1 сая төгрөг,
- XIX.1.13 Спорт заалны барилга, 250 суудал /Ховд, Дарви сум/ 1,451.4 сая төгрөг,
- XIX.1.18 Спорт заалны барилга, 250 суудал /Ховд, Цэцэг сум/ 1,712.5 сая төгрөг,
- XIX.1.30 Спорт цогцолборын барилга /Хэнтий, Баянмөнх сум/ 1,850.0 сая төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 14 дүгээр зүйлийн 14.2.3 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын 19 дүгээр зүйлийн 19.1-т заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>: Гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, хяналт хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын ажлуудыг эрчимжүүлэх албан шаардлага хүргүүлэв.*

#### 3.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1.** Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 34,286.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнээс санхүүгийн тайлангийн аудитаар 30,536.5 сая төгрөгийн 82 зөрчил илэрч, 1,219.2 сая төгрөгийн 12 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13,435.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 29 албан шаардлага хүргүүлж, 15,882.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 41 зөвлөмж өгсөн, нийцлийн аудитын асуудлаар нийт 3,749.6 сая төгрөгийн 39 зөрчил илэрч,

1.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3,213.4 сая төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага хүргүүлж, 534.6 сая төгрөгийн зөрчилд 20 зөвлөмжийг тус тус өгсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "*Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, 14.2.10.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"* гэж заасантай нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>:* Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах.

**2.** Тухайн жилийн төсвийн тухай хуулиар тус ерөнхийлөн захирагчийн багцад баталсан, аймгуудын ЗДТГ-т эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 12 барилгын 12,325.1 сая төгрөгийн төсвийн санхүүжилтийг Сангийн яамнаас шууд шилжүүлснээс Төсвийн ерөнхийлөн захирагч хуулиар хүлээсэн захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "*Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.8.хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах*" гэж заасантай нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>:* Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудад шаардлага хүргүүлэн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, хөрөнгийг төсвийн жил, гэрээний хугацаанд багтаан ажлыг гүйцэтгүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 37,385.3 сая төгрөгийн 30 алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

/сая төгрөгөөр/

| д/д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Булган аймгийн БТСГ | 1 | - | | | 1 | - | 1 | - | | | | |
| 2 | Говь-Алтай аймгийн БТСГ | 3 | 80.5 | | | 3 | 80.5 | 3 | 80.5 | | | | |
| 3 | Дорнод аймгийн БТСГ | 1 | 5.1 | | | 1 | 5.1 | 1 | 5.1 | | | | |
| 4 | Өмнөговь аймгийн БТСГ | 5 | 4,167.1 | | | 5 | 4,167.1 | 5 | 4,167.1 | | | | |
| 5 | Төв аймгийн БТСГ | 2 | 53.0 | | | 2 | 53.0 | 2 | 53.0 | | | | |
| 6 | Ховд аймгийн БТСГ | 1 | 4.0 | | | 1 | 4.0 | 1 | 4.0 | | | | |
| 7 | Багахангай дүүргийн БТСХ | 3 | 74.1 | 2 | 70.2 | 1 | 3.9 | 3 | 74.1 | | | | |
| 8 | Сонгинохайрхан дүүргийн БТСХ | 3 | 148.9 | | | 3 | 148.9 | 3 | 148.9 | | | | |
| 9 | БТСУХ | 1 | 2,038.8 | 1 | 2,038.8 | | | 1 | 2,038.8 | | | | |
| 10 | Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ | 2 | 30,500.3 | | | 2 | 30,500.3 | 2 | 30,500.3 | | | | |
| 11 | Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ | 8 | 313.6 | | | 8 | 313.6 | 8 | 313.6 | | | | |
| **Дүн** | | **30** | **37,385.4** | **3** | **2,109.0** | **27** | **35,276.4** | **30** | **37,385.4** | | | | |

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 42,861.6 сая төгрөгийн 85 зөрчил илэрснээс 1,219.2 сая төгрөгийн 12 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13,435.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 30 албан шаардлага хүргүүлж, 28,207.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 43 зөвлөмжийг хүргүүлсэн.

/сая төгрөгөөр/

| д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Монгол Улсын сайд -ТЕЗ | 3 | 12,325.1 | - | - | 1 | - | 2 | 12,325.1 | | | | |
| 2 | БТСУХ -ТТЗ | 2 | 13,239.5 | 1 | 1,172.6 | | - | 1 | 12,066.9 | | | | |
| 3 | Архангай аймгийн БТСГ | 1 | 16.7 | | | 1 | 16.7 | | | | | | |
| 4 | Баянхонгор аймгийн БТСГ | 4 | 8,743.5 | 1 | 0.3 | 3 | 8,743.2 | | | | | | |
| 5 | Булган аймгийн БТСГ | 2 | 0.7 | 1 | 0.1 | | | 1 | 0.6 | | | | |
| 6 | Говь-Алтай аймгийн БТСГ | 1 | 15.2 | | | 1 | 15.2 | | | | | | |
| 7 | Говьсүмбэр аймгийн БТСГ | 2 | 1.6 | 1 | 1.6 | | | 1 | - | | | | |
| 8 | Дархан-Уул аймгийн БТСГ | 2 | 13.8 | | | 1 | 12.0 | 1 | 1.8 | | | | |
| 9 | Дорноговь аймгийн БТСГ | 3 | 206.1 | 1 | 0.1 | 1 | - | 1 | 206.1 | | | | |
| 10 | Дорнод аймгийн БТСГ | 2 | 40.0 | | | 1 | 40.0 | 1 | - | | | | |
| 11 | Дундговь аймгийн БТСГ | 4 | 29.7 | 2 | 1.0 | 1 | 2.5 | 1 | 26.2 | | | | |
| 12 | Завхан аймгийн БТСГ | 4 | 239.6 | | | | | 4 | 239.6 | | | | |
| 13 | Орхон аймгийн БТСГ | 4 | 27.6 | 1 | 3.0 | 2 | 24.6 | 1 | - | | | | |
| 14 | Өмнөговь аймгийн БТСГ | 8 | 125.2 | 2 | 22.8 | 3 | 47.1 | 3 | 55.3 | | | | |
| 15 | Сүхбаатар аймгийн БТСГ | 1 | 8.2 | | | | | 1 | 8.2 | | | | |
| 16 | Сэлэнгэ аймгийн БТСГ | 2 | 1.7 | | | 1 | 1.7 | 1 | - | | | | |
| 17 | Төв аймгийн БТСГ | 1 | 2.0 | | | | | 1 | 2.0 | | | | |
| 18 | Ховд аймгийн БТСГ | 1 | 4.0 | | | | | 1 | 4.0 | | | | |
| 19 | Хөвсгөл аймгийн БТСГ | 3 | 0.3 | 1 | 0.3 | | | 2 | - | | | | |
| 20 | Хэнтий аймгийн БТСГ | 1 | 4.5 | | | 1 | 4.5 | | | | | | |
| 21 | Багахангай дүүргийн БТСХ | 3 | 5.9 | | | | | 3 | 5.9 | | | | |
| 22 | Баянзүрх дүүргийн БТСХ | 3 | 55.9 | | | | | 3 | 55.9 | | | | |
| 23 | Хан-Уул дүүргийн БТСХ | 2 | 20.0 | | | | | 2 | 20.0 | | | | |
| 24 | Чингэлтэй дүүргийн БТСХ | 3 | 35.1 | | | | | 3 | 35.1 | | | | |
| 25 | Нийслэлийн БТСГ | 1 | 56.6 | | | | | 1 | 56.6 | | | | |
| 26 | БТСУХ | 13 | 6,851.0 | 1 | 17.5 | 6 | 4,109.2 | 6 | 2,724.3 | | | | |
| 27 | Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ | 6 | 391.3 | | | 6 | 391.3 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ | 3 | 400.9 | | | 1 | 27.3 | 2 | 373.6 | | | | |
| **Нийт дүн** | | **85** | **42,861.6** | **12** | **1,219.2** | **30** | **13,435.2** | **43** | **28,207.2** | | | | |

**4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар нийт 3,749.6 сая төгрөгийн 39 зөрчил илэрснээс 1.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3,213.4 сая төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага хүргүүлж, 534.6 сая төгрөгийн зөрчилд 20 зөвлөмж өгсөн.

/сая төгрөгөөр/

| Д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | | | | | |
| 1 | Говьсүмбэр аймгийн БТСГ | 1 | 52.4 | | | 1 | 52.4 | | | | | | |
| 2 | Дархан-Уул аймгийн БТСГ | 1 | 88.9 | | | | | 1 | 88.9 | | | | |
| 3 | Дорноговь аймгийн БТСГ | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 4 | Өвөрхангай аймгийн БТСГ | 1 | 19.9 | | | 1 | 19.9 | | | | | | |
| 5 | Өмнөговь аймгийн БТСГ | 1 | 162.0 | | | 1 | 162.0 | | | | | | |
| 6 | Хөвсгөл аймгийн БТСГ | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 7 | Баянзүрх дүүргийн БТСХ | 1 | 43.7 | | | | | 1 | 43.7 | | | | |
| 8 | Нийслэлийн БТСГ | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 9 | Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ | 1 | 839.7 | | | 1 | 839.7 | | | | | | |
| 10 | Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ | 1 | 510.1 | | | 1 | 510.1 | | | | | | |
| **Дүн** | | **10** | **1,716.7** | | | **5** | **1,584.1** | **5** | **132.6** | | | | |
| Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | | | | | |
| 1 | Монгол Улсын сайд -ТЕЗ | 2 | - | | | | | 2 | - | | | | |
| 2 | БТСУХ -ТТЗ | 3 | - | | | | | 3 | - | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Архангай аймгийн БТСГ | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| 4 | Говьсүмбэр аймгийн БТСГ | 1 | 1.6 | 1 | 1.6 | | | | | | | | |
| 5 | Дундговь аймгийн БТСГ | 1 | 19.8 | | | 1 | 19.8 | | | | | | |
| 6 | Сүхбаатар аймгийн БТСГ | 1 | 20.0 | | | | | 1 | 20.0 | | | | |
| 7 | Сэлэнгэ аймгийн БТСГ | 1 | 54.1 | | | | | 1 | 54.1 | | | | |
| 8 | Хөвсгөл аймгийн БТСГ | 1 | 60.0 | | | 1 | 60.0 | | | | | | |
| 9 | Баянгол дүүргийн БТСХ | 1 | 25.4 | | | | | 1 | 25.4 | | | | |
| 10 | Налайх дүүргийн БТСХ | 1 | 8.3 | | | | | 1 | 8.3 | | | | |
| 11 | Чингэлтэй дүүргийн БТСХ | 1 | 23.4 | | | | | 1 | 23.4 | | | | |
| 12 | Нийслэлийн БТСГ | 1 | 270.8 | | | | | 1 | 270.8 | | | | |
| 13 | БТСУХ | 9 | 1,430.0 | | | 6 | 1,430.0 | 3 | - | | | | |
| 14 | Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ | 1 | 119.6 | | | 1 | 119.6 | | | | | | |
| 15 | Спортыг дэмжих сан | 2 | - | | | 2 | - | | | | | | |
| 16 | Спортын анагаах ухааны эрдэм шинжилгээний төв | 3 | - | | | | | 3 | - | | | | |
| 17 | Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| **Дүн** | | **32** | **2,033.0** | **1** | **1.6** | **13** | **1,629.4** | **18** | **402.0** | | | | |
| **Нийт дүн** | | **41** | **3,749.7** | **1** | **1.6** | **18** | **3,213.5** | **22** | **534.6** | | | | |